



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай

Тулгар төрийн 2227 жил, Их монгол улс байгуулагдсаны 812 жилийн ой, Ардын хувьсгалын 97 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх 2018 оны 07 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд тус төвийн үйл ажиллагаа, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг жигд тогтвортой байлгах зорилгоор ТУШААХ нь:

1. Баяр наадмын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр, эргүүл, дуудлагаар ажиллах ажиллагсадын хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгчийг орлон гүйцэтгэгч Д.Наранхүү, Технологийн тасгийн эрхлэгчийг орлон гүйцэтгэгч Х.Мядагмаа, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч М.Цэрэндэжид нарт даалгаж, шаардлагатай үед ажиллах ажиллагсадын бэлтгэлийг хангаж, дуудлагаар ажилласан хугацааг биеэр нөхөн амруулахыг тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Шаардлагатай оношлуур, хүүдий, хэрэгслийг хүлээлцэхийг Тооцооны нягтлан бодогч Н.Ууганцэцэг, техникийн саатал гарсан үед ажиллуулах нөөц цахилгаан үүсгүүр, цахим сүлжээний бэлэн байдлыг хангахыг Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн эрхлэгч Ч.Далайцэрэн нарт тус тус үүрэг болгосугай.
4. Төвийн I, II байрны аюулгүй байдлыг шалгаж, галын эрсдэлээс сэргийлэх, гэрээт харуул хамгаалалтыг өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллуулахыг Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга Ч.Батболдод үүрэг болгосугай.

5. Хариуцлагатай эргүүл, эмч, жижүүрийн сувилагч нарт даалгах нь:
- 5.1. хариуцлагатай эргүүл, жижүүрийн сувилагч нар ЦЦБ-ний нөөц, үйлчилгээний талаар өдөр бүр 2 удаа /08.00-16.00 цагийн мэдээг 17.00 цагт, 16.00-08.00 цагийн мэдээг 09.00 цагт/ ЦССҮТ-ийн Ерөнхий захирал болон ЭМЯ-ны хариуцлагатай жижүүрт 323002 дугаарын утсаар мэдээлэл өгөх;
 - 5.2. баярын үеэр үүрэг гүйцэтгэж ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн сувилагч нар ажлын байранд мөрддөг дүрэм журам, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахин хариуцлагатай, өндөр сонор сэрэмжтэй ажиллаж, ямар ч тохиолдолд холбоо барих боломжтой байх /гар утсаа унтраахгүй нээлттэй байлгах;
 - 5.3. хариуцлагатай эргүүл, жижүүрийн сувилагч нарын анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг асуудал гаргахгүй байх;
 - 5.4. төвийн барилгын аюулгүй байдлыг шалгаж, галын эрсдэлээс сэргийлэх, төвийн II байрны харуултай хоногт 3 удаа холбогдож, бүтээгдэхүүн хадгалж байгаа хөргөгч, хөлдөөгчийн хэмийн хяналтыг асууж, жижүүрийн дэвтэрт тэмдэглэх;
 - 5.5. хариуцлагатай жижүүрийн дэвтэрт жижүүрийн тэмдэглэл хөтлөх, шаардлагатай үед утсаар ярьсан тохиолдол бүрийг тэмдэглэж, мэдэгдэх;
 - 5.6. шаардлагатай үед дуудах донорын карт, цус цуглуулах, шинжилгээ хийх, ЦЦБ үйлдвэрлэхэд шаардлагатай оношлуур хүүдий, багаж хэрэгслийг бэлэн байлгаж, хүлээлцэх;
 - 5.7. цахилгаан тасарсан үед ажиллуулах нөөц цахилгаан үүсгүүрийг бэлэн байлгаж, шаардлагатай үед хуваарийн дагуу инженерүүдийг дуудаж ажиллуулах;
6. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга Ч.Батболдод даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
 018 оны 07 сарын 09 өдрийн
 №34 тоот тушаалын хавсралт

Хариуцлагатай эргүүл, жижүүр, шаардлагатай үед дуудлагаар ажиллах ажилтнуудын хуваарь

Сар өдөр	Ажиллах жижүүрийн сувилагч	Хариуцлагатай эргүүл	Шаардлагатай үед ажиллах инженерүүд	Дуудагдаж ажиллах эмч тусгай мэргэжилтнүүд	Дуудагдаж ажиллагсдын утасны дугаар
VII/11	С.Нандинчимэг	Ө.Бат-Эрдэнэ 99099875	Ч.Далайцэрэн 88544430 Б.Додьгалсан 88304061	Х.Мядагмаа Г.Отгончимэг С.Хаян Б.Анударь Р.Энхтуяа Д.Одмаа	88820550 88919206 94247656 95680512 99044887 80610880
VIII/12	У. Пүрэвсүрэн	Н.Ууганцэцэг 80055510	Ч.Далайцэрэн 88544430 Б.Додьгалсан 88304061	Х.Мядагмаа Н.Энхтуул С.Хаян Б.Анударь Р.Энхтуяа Д.Одмаа	88820550 99084759 94247656 95680512 99044887 80610880
VII/13	О.Мөнхцэцэг	С.Алтаннамар 91990619	Ч.Далайцэрэн 88544430 Б.Додьгалсан 88304061	Х.Мядагмаа Н.Энхтуул С.Хаян Б.Анударь Р.Энхтуяа Д.Одмаа	88820550 99084759 94247656 95680512 99044887 80610880
VIII/14	С.Нандинчимэг	Б.Додьгалсан 88304061	Ч.Далайцэрэн 88544430 Б.Додьгалсан 88304061	Х.Мядагмаа П.Цэндхүү С.Хаян Б.Анударь Р.Энхтуяа Д.Одмаа	88820550 99868300 94247656 95680512 99044887 80610880
VIII/15	У. Пүрэвсүрэн	Ж.Нармандах 98115966	Ч.Далайцэрэн 88544430 Б.Додьгалсан 88304061	Х.Мядагмаа Б.Долгормаа С.Хаян Б.Анударь Р.Энхтуяа Д.Одмаа	88820550 94019433 94247656 95680512 99044887 80610880

1119766543-9129905